

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2023-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 02 дугаар сарын 02

Улаанбаатар хот

№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилго, зорилт	Стратегийн зорилт /Хэрэгжүүлэх арга хэмжээ/	Шалгуур үзүүлэлт /Тоо, чанар/	Суурь түвшин /2022 он/	Зорилтот түвшин /Өссөн дүнгээр/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>Стратегийн зорилго 1. Гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх.</b>							
1		Албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилнэ.	Тоо	1	1	Газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар тушаалаар “Түр орон байраар хангах алба”-ны орон тооны бус штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, гамшигаас хамгаалах төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган тайлагнан ажиллав.	100
2	1.1. Нийслэлийн түр хоргodoх орон байраар хангах албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, бэлэн байдлыг ханган ажиллана.	Нийслэлийн түр орон байрны бэлэн байдалд явцын хяналт хийж, заавар зөвлөгөө өгөх, Онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллана.	Тоо	1	2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/194 дүгээр “Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Гамшигийн үед түр орон байраар хангах байрны удирдлагуудад цаг үеийн асуудлаар мэдээлэл хүргэх сургалтыг Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж “Барилгын чанар, аюулгүй байдал” сэдвийн хүрээнд мэдлэг олгож, зөвлөгөө өгөв. Сургалтад түр орон байраар хангах 344 байгууллагын төлөөлөл хамрагдсан.	100
3	1.2. Гамшигийн үед байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг, өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, нутгийн захиргааны байгууллага, салбар хоорондын харилцан ажиллагааг оновчтой зохион байгуулах, гамшигаас хамгаалах	Гамшигийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөл, Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.	Хувь	100	100	Гамшигийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөл, газар хөдлөлтийн гамшигаас сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд тогтмол оролцож, 2023 оны төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлт, зөвлөлийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгуулах саналаа Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын	100

1	2	3	4	5	6	7	8
	бэлэн байдлыг хангаж ажиллана.					албанад 2023 оны 01/07/3154 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	

**Стратегийн зорилго 2. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ. (НЗДҮАХ-ийн 6.1)**

**Орон зайн оновчтой төлөвлөлт**

4	2.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Тоо	-	1	<p>Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн барих ажлын хүрээнд "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газрын 16 яам, Шадар сайд, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Автозамын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга нараас санал авч дууссан. Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2023 оны 94/A/443 тоот тушаал, захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгээс "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичигт "Сонсголонт хот", "Сэлбэ сэргэлт" төслийг уялдуулан, баяжилт хийж боловсруулах үүрэг даалгавар өгсөн. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 35 дугаар хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн дагуу "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж, ажлын даалгавар боловсруулан үүрэг даалгаврын</p>	90
---	---	--	-----	---	---	--	----

1	2	3	4	5	6	7	8
						<p>дагуу ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсны дараа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөрөнгө оруулалтын нарийвчилсан тооцооны хамт Монгол Улсын Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	
5	Хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө	Хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө	Too	2	7	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/372 дугаар захирамжийг үндэслэн Зайсан толгой орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр №2023/10 дугаартай батлагдсан. Зайсан толгой орчмын нийт 708 га талбайд хийгдэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засаг, байгаль орчин, газар нутгийн одоогийн байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, иргэдийн аюулгүй байдал тав тухтай орчин бүрдүүлэхийн тулд гудамж зам, инженерийн шугам сүлжээ, нийгмийн дэд бүтцийн оновчтой төлөвлөлтийг боловсруулах зорилготой зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагын сонгон шалгаруулалтын зарыг Хот байгуулалтын зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл бүхий 19 байгууллагад 2023 оны 2/3177 дугаартай албан бичгээр мэдэгдэж хамтран ажиллав.</li> <li>- Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/893 дугаар захирамжаар "Яармаг" хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т, захиалагчийн хяналт</li> </ul>	90

1	2	3	4	5	6	7	8
						тавьж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газарт тус тус даалгасан. Тус захирамжийн хүрээнд “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2023/A/893/01 дугаар бүхий ажлын гэрээ батлагдаж, 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр гэрээнд тусгагдсаны дагуу дундын тайлангийн шатанд байна. - Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 12 дугаар хурлаар хэлэлцүүлж, 65 дугаар тогтоолоор батлагдсан.	
6	Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрэм	Хотын	Toо	-	1	“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлуулсны дараа хийгдэх ажил тул хугацаа болоогүй.	0
7	Хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох шийдвэр		Toо	1	1	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04-т заасан хүн амын тооцоот нягтрал 1 га газарт 460 хүн байх хязгаарыг давсан 6 дүүргийн 111 хэсгийн 1163 га газрын нягтралын судалгааг гаргаж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр хурлаар хэлэлцүүлэн “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан.	100
8	Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө		Toо	-	1	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хургуулсан боловч хөрөнгө	0

1	2	3	4	5	6	7	8	
						шийдвэрлэгдээгүй. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал өгсөн.		
<b>Олон төвт хот</b>								
9	2.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, шинжлэх ухаан, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж хотын хэт төвлөрлийг бууруулна.	Хотын дэд төв	Toо	-	10	Сонсголон, Амгалан, Шинэ төв дэд төвийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах ажлын дундын болон эцсийн тайланд хяналт тавин гадна шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл санал хүргүүлж, төлөвлөлтийн шийдэл зөвшилцсэн. 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр магадлалын ерөнхий дүгнэлт батлагдаж эцсийн тайлан хүлээн авах шатанд байна. Магадлалын дүгнэлтийг баталгаажуулан 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авсан. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	90	
<b>Ухаалаг технологи</b>								
10	2.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем /барилга барих зөвшөөрлийг цахимжуулах систем/	Хувь	80	100	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/923, 2023 оны А/73 дугаар захирамжийн дагуу "Смартдата" ХХК-тай байгуулсан НХААГ/202212160, НХААГ/202212160-1 дугаартай гэрээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж, эцсийн тайланг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ХБМХ-2023/06 дугаартай актаар сервер, тоног төхөөрөмж, eBarilga geопортал, гар утасны аппликацийн эх файл, дотоод удирдлагын системийн гарын авлага зэргийг хүлээн авсан.	100	
<b>Орон сууц, нийтийн аж ахуй</b>								
11	2.4. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна.	Буулгасан шаардлага барилга	ашиглалтын хангахгүй	Toо	61	64	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын	100

1	2	3	4	5	6	7	8
						дагуу 2015 оноос хойш Нийслэлийн Засаг даргын 19 удаагийн захирамжаар 178 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарсан. 2015-2023 оны хооронд нийт 106 барилга дээр төсөл хэрэгжүүлэгч шалгарч, 1444 өрхийн 67 барилгыг буулгаж, 3270 өрхийн үйлчилгээ, орон сууцны 26 барилгыг барьж ашиглалтад оруулсан байна. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн санал ирээгүй 22 багцын 52 барилгын барилгажилтын төслийн үр ашгийн тооцоог гаргаж, мөн нөхцөл байдал хүндэрсэн байршуудыг чөлөөлөх талаар санал боловсруулж, танилцуулга бэлтгэсэн.	
12		Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа, загвар зураг төсөл	Тоо	207	207	Улс, нийслэлийн төсөвт хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	0
13	2.5. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчинтгэлийн зураг боловсруулж, лаборатори байгуулна.	Дүгнэлт гаргаж, паспортжуулсан барилга	Тоо	944	962	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/11 дүгээр "Эрх шилжүүлэх тухай" захирамжийн хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системээр олон нийтэд нээлттэй тендерийг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр нээсэн нь шаардлагад нийцээгүй тендер гэж дүгнэн татгалзаж, дахин тендер зарлахаар шийдвэрлэсэн байна. Дахин худалдан авах ажиллагааны цахим системээр 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй тендерийг зарлан тендер шалгаруулалтыг 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулан амжилттай тендер гэж дүгнэн Зураг төслийн "ЭГЭ" ХХК-тай 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн НХБХГ/10/04/202305 дугаартай	100

1	2	3	4	5	6	7	8
						ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Тус гэрээний дагуу "ЭГЭ" ХХК-иас 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр эхлэлийн тайлан, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр эцсийн тайланг ирүүлсэн бөгөөд 18 барилгын Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг хүлээлгэн өгсөн байна.	
14	Гамшигт тэсвэртэй амины сууцны загвар зураг	Тоо	-	5		Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/554 дүгээр захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг боловсруулах ажилд 100 сая төгрөг батлагдсан. Нийслэлийн Худалдан, авах ажиллагааны газраас зарласан сонгон шалгаруулалтаар "Эм Эм Инженеринг" ХХК шалгарч, 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 96.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Эцсийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авах байснаас "Эм Эм Инженеринг" ХХК-ийн гэрээ сунгах хүсэлтийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаагаар гэрээний хугацааг сунгасан. 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр эцсийн тайланг ирүүлсэн бөгөөд гүйцэтгэлийг хянаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 01/07/1047 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Нэг маягийн зураг төслийг иргэд олон нийтэд нээлттэй ашиглуулахад бэлэн болсон байна.	100

#### Бус, орон нутгийн хөгжил

**Стратегийн зорилго 3. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бус, орон нутгийн хөгжлийн уялдааг ханггуулна. (НЗДҮАХ-ийн 6.2)**

15	3.1. Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.	Жаргалант, Рашиант, 361-ийн гарам дагуул тосгодын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	Тоо	-	1	Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан "Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг	30
----	--	--	-----	---	---	---	----

1	2	3	4	5	6	7	8
						Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Тус ажлыг Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.	
16	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого	Too	-	1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ, байршил тодорхой болох тул хэрэгжилтийн хугацаа болоогүй. Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас гаргасан хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 18-ний өдөр дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах газрын байршилтай танилцах аяллын хүрээнд Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Туушин логистикийн төсөл, Майдар хот төсөл, Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал болон ойр орчмын бүтээн байгуулалт, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцаж чиглэлийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн.	30	

## Дэд бүтэц

**Стратегийн зорилго 4. Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. (НЭДҮАХ-ийн 6.3)**

## Инженерийн бэлтгэл арга хэмжээ

17	4.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө	Инженерийн бэлтгэл арга хэмжээний бодлогын	Хувь	90	100	Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын	100
----	--	--	------	----	-----	--	-----

1	2	3	4	5	6	7	8
	болон өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулан батлуулна.	баримт бичгийн боловсруулан батлуулсан байх ажлын хувь				яамны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдөр Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 12 дугаар хурлаар хэлэлцүүлж 65 дугаар тогтоолоор батлагдсан.	
18	4.2. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.	Улиастай голын эргийн хамгаалалтын далангийн урт	Kм	-	1.6	Улс, нийслэлийн төсөвт санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	0
19		Нисэхийн үерийн хамгаалалтын далан сувгийн угсралтын урт	Kм	-	1.1	Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Нисэхийн үерийн хамгаалалтын сувгийн 1.1 км ажлын зураг төсөл зөвшилцсэн. Барилга угсралтын ажлыг "Геодез, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ гүйцэтгэхээр Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай гэрээ байгуулан ажиллаж байна.	70
20		Жаргалантын амны үерийн хамгаалалтын сувгийн угсралтын урт	Kм	-	1.0	Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хорооны Жаргалантын амны үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төсөл зөвшилцсэн. 2024 онд барилга угсралтын 2 дугаар ээлжийн ажил хийгдэхээр нийслэлийн төсөвт тусгагдсан.	70
21		Туул голын эргийн хамгаалалтын далан сувгийн угсралтын урт	Kм	-	24	Туул голын үерийн хамгаалалтын далан сувгийн засвар шинэчлэлтийн ажлын төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч байгууллагаар "Хайдродизайн проект" ХХК шалгарсан. Нийт 24 км үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төслөөс 1,7 дугаар хэсгийн 6,0 км үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төсөл зөвшилцсэн.	100
22		Үерийн далан, сувгийн урт	Kм	152,1	155.1	Улаанбаатар хотын хэмжээнд 12 байршилд нийт 52 км үерийн хамгаалалтын далан сувгийн ажлын зураг төсөл хийгдсэн. Барилга угсралтын ажлын барилга угсралтын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр улс, нийслэлийн төсөв болон Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.	30

1	2	3	4	5	6	7	8
23		Зам талбайн борооны ус зайлуулах шугамын урт	Км	47,8	47.8	Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-уул дүүрэгт төвийн болон зүүн хэсгийн 68 км төв коллектор борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлын барилга угсралтын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр улс, нийслэлийн төсөв болон Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.	30
24		Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний урт	Км	22,7	27.1	Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд Хан-Уул дүүргийн 1,2,3,15,17,18,19,20 дугаар хороонд 27.3 км хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төсөл хийгдэж зөвшилцсэн. Тухайн ажлын барилга угсралтын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр улс, нийслэлийн төсөв болон Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.	30
25		Засвар, шинэчлэлт хийх үерийн далан сувгийн урт	Км	3,0	3.5	Тухайн ажлын барилга угсралтын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр улс, нийслэлийн төсөв болон Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.	0

#### Усан хангамж

26	4.3. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барина.	Толгойт, Их наран орчимд усан сан, шугам сүлжээний барилга угсралтын урт	Км	-	14.5	"Хайдродизайн инноваци" ХХК Толгойтын усан сан, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг хийж гүйцэтгэсэн. - СХД-ийн 4-р хороо, Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф300мм - ийн 2,8 км шугамын барилга угсралтын ажил хийгдсэн. - Их Нарангийн усан сан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралт хийгдэж байна.	70
27		Буянт-Ухаа 2 хороолол орчим баригдах усан сан, шугам сүлжээний барилга угсралтын хувь	Хувь	-	60	"Буянт Ухаа-2" хорооллын 2 дугаар ээлжийн Солонго-1,2 төслийн ус хангамжийн шугам сүлжээний зураг төслийг зөвшилцв. - Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны орон сууцны хорооллын ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар 2022 оны 11 дүгээр хурлаар батлагдсан. Зураг	70

1	2	3	4	5	6	7	8
						төслийн хүрээнд шинээр төлөвлөж буй усан сангийн байршлын газар олголтын асуудлыг шийдүүлсний дараа зураг төслийг зөвшилцөнө. <b>Үр дүн:</b> Насос станц, УДХТ-ийн газар олголт хийгдсэн.	
28		Зайсан орчмын усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын урт	Км	-	0.9	Зайсан орчмын орон сууцны хороололд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажил хийгдэж байна. Захиалагчийн хяналтыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар хариуцан гүйцэтгэж байна. Хан-Уул дүүргийн 11 хорооны нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем (Хан-Уул дүүрэг)-ийн угсралтын ажлыг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн Барилга хот байгуулалтын яаманд байгуулагдан ажиллаж байна.	70
29		Ус хангамжийн шугамын урт	Км	589,9	593.8	Залуус-2" төслийн усан сан шугам сүлжээний ажлын зураг төсөл хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр инженерийн шугам сүлжээний хонгилын барилга угсралтын ажил хийгдэж байна.	70
30		Шинээр нэмэгдэх ариутгах татуургын шугамын урт	Км	9	5.5	- Бүянт-Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн төслийн ариутгах татуургын шугамын 1,3 дугаар ээлжийн ажлын зураг төсөл ф500/ф600 мм-ийн 2.1 км шугамын ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 1-р хэсгийн барилга угсралтын ажил хийгдэж байна. - Гандан хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг "Кингсий инженер энд констракшн" XXX баталгаажуулсан.	70
31	4.4. Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.	Зүүн хойд бүсийн усан сангийн эзлэхүүний хэмжээ	м³	14,000	22,000	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд Зүүн хойд бүсийн усан санг өргөтгөн шинэчлэх ажлын зураг төслийг баталгаажуулсан. Хот	30

1	2	3	4	5	6	7	8
						байгуулалтын мэдээллийн санд төлөвлөлтийн мэдээллийг оруулсан. 2023 онд хөрөнгө оруулалт шийдэгдээгүй тул хэрэгжих боломжгүй байна. Нийслэлийн 2022 оны төсөв, Нийслэлийн 2022 оны төсвийн тодотгол, Нийслэлийн 2023 оны төсөв, Нийслэлийн 2023 оны төсвийн тодотголд хөрөнгийг тусгуулахаар санал өгч ажилласан.	
32	Налайх дүүргийн усан сан, шугам сүлжээний барилга угсралтын хувь	Хувь	10	100	2023 онд хөрөнгө оруулалт шийдэгдээгүй тул хэрэгжих боломжгүй байна. Нийслэлийн 2023 оны төсөв, Нийслэлийн 2023 оны төсвийн тодотголд хөрөнгийг тусгуулахаар санал өгч ажилласан.	30	
33	Өргөтгөл, шинэчлэлт хийгдэх ус хангамжийн шугамын урт	Kм	2,7	1.8	Иргэн, хуулийн этгээдийн 121 байршилд ус хангамж, ариутгах татуургын ажлын зураг төслийг зөвшилцсэн.	100	
34	Өргөтгөн шинэчлэх ариутгах татуургын шугамын урт	Kм	4,2	0.4		100	
35	4.5. Ус хангамжийн шугамыг шуудуу ухалгүй доторлох төслийг хэрэгжүүлж дуусгаж, зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулсан ус түгээх барилга	Toо	342	357	Баянгол дүүргийн 9,10,11 дүгээр хорооны зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбох ажлыг "Хайдродизайн инноваци" ХХК гүйцэтгэж байна. Шинээр төлөвлөж байгаа усан сан, насос станцын байршил сонгох шугам сүлжээний трасс зөвшилцэх ажил хийгдэж байна. Шугам сүлжээний мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан байна. Ус түгээх байруудад ухаалаг төхөөрөмж суурилуулах ажлыг Мянганы сорилтын сангаас буцалтгүй тусламжаар хийгдэх ажлын хурээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	70	
36	4.6. Шинээр цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулах бөгөөд хуучин байгууламжуудад техник технологийн шинэчлэлт хийнэ.	Улаанбаатар хотын "Төв цэвэрлэх байгууламж"-ийг шинэчлэн барьж ашиглалтад оруулах бүтээн байгуулалтын хувь	Хувь	10	100	Шинэ цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсөл зөвшилцсэн бөгөөд барилга угсралтын ажлын бүтээн байгуулалт хийгдэж байна. Төв цэвэрлэх байгууламжийн гадна инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил	70

1	2	3	4	5	6	7	8
						хийгдэж дууссан. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан байна.	
37	Aриутгах татуургын Туул-1 коллекторын 3, 4 дүгээр ээлжийн шугамын барилга угсралтын урт	Kм	-	9.4	-	-Туул-1 бохир усны шугамын ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/474 дүгээр захирамжаар ажлын зургийн өөрчлөлт 110.0 сая төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/232 дугаар захирамжаар 3,4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажилд 3.190,2 тэр бум төгрөг батлагдсан. Туул-1 коллекторын трасст орсон иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн мэдээллийг гаргаж, ажлын зургийн өөрчлөлтэд тусгахаар ажлын зураг төслийн Монхайдро ХХК, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба хамтран ажиллаж байна.	70
38	Aриутгах татуургын Толгойт-2 коллекторын барилга угсралтын урт	Kм	-	0.9	-	Толгойт дэд төвийн шугам сүлжээний ажлын зураг төсөлд тусгаж ажлын зураг зөвшилцсэн. Шугамын барилга угсралтын ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэнэ.	70
39	Дарь-Эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын угсралтын урт	Kм	-	2.3	-	Дарь-Эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөл зөвшилцсэн. 2022 оноос эхлэн шугамын барилга угсралтын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр Бумбод ХХК гүйцэтгэж байна. Шугам сүлжээний мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан.	100
40	Буянт-Ухаа орон сууцны хорооллын бохир ус цэвэрлэх байгууламжийн дулааны шугам сүлжээний бүтээн байгуулалтын хувь	Хувь	10	50	-	Бохир усны цэвэрлэх байгууламжийн гадна шугам сүлжээний ажил бүрэн хийгдэж дууссан.	100
<b>Эрчим хүч</b>							
41	4.7. Цахилгааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, сүлжээний хамрах хүрээг өргөтгэн, өсөн нэмэгдэж	10/0.4 кВ-ын хүчин чадалтай шинэчилсэн болон шинээр барьсан дэд өртөө	Toо	1,453	1,563	2023 онд 10(6)/0.4 кВ-ын улсын болон хувийн эзэмшлийн 417 дэд өртөө шинээр баригдсан байна.	100

1	2	3	4	5	6	7	8
42	байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	35/10 кВ-ын хүчин чадалтай шинээр барьсан болон шинэчилсэн дэд станц	Тоо	63	64	Б3Д-ийн 14-р хороо, Ар хөндлөнгийн аманд 35/10кВ дэд станцын барилга угсралтын ажил хийгдэж байна. Зуслангийн бүсэд 35/10кВ-ын 2 дэд станц баригдахаар Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-с санал ирүүлсэн бөгөөд 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал хүргүүлсэн. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийн цахилгаан хангамжийг шийдэх зорилгоор 35/10кВ-ын 2 дэд станц төлөвлөгдсөн бөгөөд 2024 оны төсвийн тодотгол, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.	30
43		220/110 кВ-ын 2x125 МВА чадалтай Налайх дэд станцын бүтээн байгуулалт	Хувь	60	100	Тус станцын хүчин чадал нэмэгдүүлэх ажлын зургийг Мастерпойнт ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд барилга угсралтын ажил эхлээгүй байна.	30
44		Улаанбаатар дэд станцын 2x220 МВА-ийн хүчин чадалтай болгож тоноглож шинэчлэх бүтээн байгуулалт	Хувь	60	100	Тус станцын хүчин чадал нэмэгдүүлэх ажлын зургийг Мастерпойнт ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд барилга угсралтын ажил эхлээгүй байна.	30
45		110/35/10 кВ-ын 2x40 МВА чадалтай дэд станц	Км	30	-	110/35/10кВ 2x40МВА гэр хорооллын айл өрхийг цахилгаан эрчим хүчээр халаах, агаарын бохирдол бууруулах зорилтын хүрээнд Ханын материал, Дамбадаржаа, Баянхошуу дэд станцын ажлын зураг төсөл хийгдсэн, барилга угсралтын ажлын тесөв батлагдаагүй байна.	30
46		Шинээр татсан 110 кВ-ийн агаарын шугамын урт	Км	253	256.2	Налайх, Багахангай чиглэлийн 220, 110, 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн, барилга угсралтын ажил хийгдээгүй байна.	30
47		50 МВт чадалтай цэнэг хураагуурын станц барих ажлын хувь	Тоо	0	60	80МВт чадалтай 200МВт.цагийн багтаамжтай цэнэг хураагуурын станцын угсралтын ажил дуусаж, 2023 оны 12 дугаар сард 220/110/35кВ-ын Сонгино дэд станцад холбогдож сүлжээнд залгагдсан.	100

1	2	3	4	5	6	7	8
48		Шинээр татсан кабель шугамын урт	Км	1,401	1,620	2023 онд улсын болон хувийн хэвшлийн нийт 28,5км 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам шинээр татагдсан.	70
49		Шинэчилсэн болон шинээр татсан 10,35 кВ-ийн агаарын шугамын урт	Км	5,911	6,840	Улаанбаатар хотод 2023 онд улсын болон хувийн хэвшлийн нийт 90,7км 10кВ цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр баригдсан байна. 35кВ шугам хийгдээгүй байна.	70
50	4.8. Дулаан, цахилгааны станц шинээр барих, өргөтгөх, технологийн шинэчлэл хийнэ.	Шинээр барьсан дулааны цахилгаан станц	мВт	-	3	<ul style="list-style-type: none"> <li>- Налайх дүүрэг 180 МВТ-ийн дулааны станцын ажлын зураг төсөл хийгдэж дууссан, 2023 оны улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.</li> <li>- Дамбадаржаа 63МВт-ийн дэд төвийн дулааны станцын ТЭЗҮ, ажлыг зураг төсөл дууссан Гэр хорооллыг хөгжүүлэх харанга оруулалтыг дэмжих хөтөлбөр төслөөр хэрэгжихээр газар чөлөөлтийн ажил бүрэн хийгдсэн. Нийслэлийн 2024 оны төсвийн тодотголд оруулсан. Барилга угсралтын ажил 50 хувьтай</li> </ul> <p><b>Үр дүн:</b> Сэлбэ дэд төвийн дулааны станц 2021 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орсон. Тус дулааны станцын 7МВт-ын халаалтын 1 зуух ажиллагаанд залгагдсан бөгөөд 39 аж ахуйн нэгж байгууллага төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдсон. Одоогийн байдлаар Сэлбэ дулааны станцад холбогдсон 38 ширхэг хэрэглэгчид холбогдон хэрэглэгчдийн нийлбэр ачаалал 4.11Гкал/цагийн хэрэглээтэй байна.</p>	90
51		Хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөсөн дулааны станц	мВт	-	3	<ul style="list-style-type: none"> <li>- Амгалан дулааны станцыг 116 МВт (100 Гкал/цаг) хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, БНХАУ-ын "Хунан индастриал экуйпмент инсталейшн" ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэй барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан. Уг гэрээний дагуу гүйцэтгэгч компаниас зураг төслийн ажлыг гүйцэтгэж байна.</li> </ul>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>- Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм лизинг” ХХК-иас санхүүгийн түрээсийн судалгааг хийж дуусган 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр төслийн 85%-ийг буюу 65.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлэх шийдвэр гаргасан. Үүнтэй холбогдуулан санхүүгийн түрээсийн гэрээ, хамтран ажиллах гэрээ болон бусад гэрээнүүдийг байгуулан ажиллаж байна. Амгалан дулааны станцын суурイラгдсан хүчин чадал 300Гкал/цаг бөгөөд 485.5 Гкал/цаг-ийн хэрэглэгчид төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдсон. Тус станцын орчимд холбогдохоор хүлээгдэж буй 100Гкал/цаг орчмын хэрэглэгчид байна.</p> <p>- “Амгалангийн дулааны станц”-ыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөхөөр Нийслэлийн 2024 оны тодотголд оруулсан</p> <p><b>Үр дүн:</b> 2024 онд ашиглалтад орох төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	
52	4.9. Дулааны гол магистраль шугамын урт, дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.	Өргөтгөн шинэчилсэн дулааны шугамын урт	Км	27.5	37.05	<p>- Улсын тесев болон Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр төвлөрсөн дулаан хангамжийн өргөтгөл шинэчлэлтийн 2ф200/350/400/500/ 700/800/1000мм-ийн голчтой 8.404км дулааны шугамын барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөгдсөн.</p> <p><b>Үр дүн:</b> Сэлбэ дулааны станцаас хангагдах УДДТ-12, 1,2 км дулааны шугам сүлжээ ашиглалтад орсон.</p> <p>- ТЭЦ-3-аас холбогдсон 5 дугаар магистралийн өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэн.</p> <p>- Төвлөрсөн дулаан хангамжийн 10вгд магистраль шугамын ОЦ-1050 /ТК703/-р цэгээс 3д магистралын 22 дугаар онцлог хүртэл 2ф1000 мм-ийн голчтой дулааны шугам шинээр татах, мөн цэгээс насос станц №3 хүртэл 2ф800 мм-ийн голчтой шугамыг 2ф1000 мм-ийн голчтой болгож өргөтгөх</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>ажлын зургийн даалгаварт санал хүргүүлж, төвлөрсөн дулаан хангамжийн шинэчлэлтийн ажлын зураг төсөл зөвшилцсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1а магитраль, ДХ-110-17 цэгээс Зайсангийн ДДТ /одоо байгаа/ хүртэлх 2ф300мм-н голчтой шугамыг 2ф350мм болгож 380хос метр болгон өргөтгөх ажлыг Нийслэлийн 2024 оны төсвийн тодотголд оруулсан.</li> </ul>	
53	Шинээр барьсан дулааны шугамын урт	Kм	6	12		<p>Улсын төсөв болон Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр төвлөрсөн дулаан хангамжийн өргөтгөл шинэчлэлтийн 2ф600/400мм-ийн голчтой 1.8км дулааны шугамын барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөгдсөний дагуу ажлын зураг төсөл зөвшилцсэн.</p> <p><b>Үр дүн:</b> Зураг төслүүд зөвшилцсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Залуус-1” орон сууцны хорооллын төслийн шугам сүлжээний хангач байгууллага “УБДС” ТӨХК-аас олгогдсон 7.5 Гкал/цаг-ийн техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн дулаан хангамжийн 13 дугаар магистраль шугамаас хангадах 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, дулааны эх үүсвэрээс хангадах дулаан хуваарилах төвтэй хосолмол ажиллагаатай ажиллах ажлын зураг төсөл,</li> <li>- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн нэгжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Сонгдо Монголиа эмнэлгээс эхлэн Ногоон нуурын урд хэсэгт төлөвлөж буй Дэнжийн 1000 дэд төвийн дулааны станцаас би магистраль шугамтай холбох 2ф350мм-ийн голчтой 1.1км гадна дулааны шугамын ажлын зураг төсөл,</li> <li>- Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороонд байрлах даралт өргөх насосны №2 станцын шахах талаас ф350мм-ийн өгөх шугамаас</li> </ul>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>эхлэн Дэнжийн 1000-ын салаа шугамтай холбох дулааны шугамын ажлын зураг төсөл,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Баянгол дүүргийн 7,8,12,13 дугаар хорооны нутаг дэвсгэр, Соломолл худалдааны төвийн замын урд талаас эхлэн ОСНААУГ-ын ДДТ-95 хүртэл шинээр татах 2ф400мм-ийн голчтой шугамын ажлын зураг төсөл,</li> <li>- Баянгол дүүргийн 11,13,15 дугаар хорооны нутаг дэвсгэр, Нарлаг худалдааны төвийн зүүн талбай Бичил б дугаар хороолол буюу 28 дугаар сургуулийн баруун хойд тал хүртэл төвлөрсөн дулаан хангамжийн насосны №6 станцын ачааллыг хөнгөлж, С-728 халаалтын цогц төхөөрөмжийн 2 дугаар хэлхээнд МҮОНРТ, Сэтгэмж цогцолбор сургууль орчмын хэрэглэгчдийг дулаанд шинээр холбох 2ф350мм-ийн голчтой дулааны шугамын ажлын зураг төсөл.</li> <li>- X, XVII. Шархад нэгж хорооллын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох 2.25км шугамыг Нийслэлийн 2024 оны төсвийн тодотголд оруулсан.</li> </ul>	
54	4.10. Хатуу түлшний халаалтын зуухнуудыг ўе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбох, хийн түлшинд шилжүүлнэ.	Хийн түлшний дулааны эх үүсвэр	Toо	1	2	<p>Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны V дугаар хуралдааны 01 дүгээр хурлын тэмдэглэлээр Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай 80 Гкал/цаг-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ дэмжигдсэн. Тус станц нь Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт 3,8 га нэгж талбарт төлөвлөгдсөн ба нөлөөлөлд өртсөн 58 нэгж талбараас:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 21 нэгж талбарт нөхөх олговор олгож газар чөлөөлсөн,</li> <li>✓ 10 нэгж талбарыг чөлөөлөхөөр зөвшилцсөн,</li> <li>✓ 27 нэгж талбартай зөвшилцж байна.</li> </ul> <p>/Эх сурвалж: Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба/</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бүсэд түүхий нүүрс хэрэглэдэг халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хөрөнгө шийдвэрлэгдсэн. Уг ажлын барилга угсралтын ажил дууссан.</p> <p>- Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжид Нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн 10 байршилд сургууль, цэцэрлэгийн барилгын халаалтын зуухыг шинэчлэн хийн түлш болон сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэртэй хосолмол ажиллагаатай ажиллах ажлын зургийн даалгавар батлуулж хүргүүлсэн.</p> <p>- Нисэх, Яармаг орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийн түлшний дулааны эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах зардлыг 2023 оны Улс, нийслэлийн төсөвт тусгуулах саналыг албан бичгээр хүргүүлсэн.</p> <p><b>Үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн 105 дугаар сургууль орчмын хийн дулаан станцын зураг төслийн ажлын хөрөнгө оруулалт 126.7 сая төгрөг батлагдсан.</li> <li>- 2023 онд 5 хийн хангамжийн ажлын зураг төсөл зөвшилцсэн.</li> <li>- Сүхбаатар дүүргийн 17-р хороо, 58 сургууль 2022 онд хийн түлшний эх үүсвэртэй болсон.</li> </ul> <p>Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүндрэлтэй (хөлдөлт үүсэх эрсдэлтэй) цэгүүдэд оргил ачааллын горимд ажиллах хийн түлшний тархмал 4 эх үүсвэрийг шинээр барихаар төлөвлөж байгаа бөгөөд эхний ээлжид Насос станц урд Цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд Дүнжингарав худалдааны төвийн замын урд мөн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшил газарт,</p>	

1	2	3	4	5	6	7	8
55						Зайсан Хөдөө аж ахуйн их сургуулийн Агропаркийн хашаанд, Хилийн цэргийн 124 дүгээр ангийн газарт хийн дулааны станцын судалгааг тус тус боловсруулсан болно.	
		Хатуу түлшнээс хийн түлшинд шилжсэн аж ахуйн нэгж байгууллага	Тоо	40	50	2019-2023 онуудад улс, нийслэлийн төсвөөр нийт 25 аж ахуйн нэгжийг хийн түлшний халаалтын системд холбосон.	100
<b>Мэдээлэл, холбоо</b>							
56	4.11. Мэдээлэл холбооны нэгдсэн төвүүдийг байгуулан ёндер хурдны сүлжээнд холбож, ухаалаг хот байгуулах нэгдсэн цагариг сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.	Мэдээлэл холбооны нэгдсэн төв	Тоо	13	14	Улаанбаатар хотод мэдээлэл холбооны ЭАТС, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, сүлжээ зохион байгуулалтыг сайжруулаа ажлын зураг төсөл боловсруулагдсан. Барилга угсралтын ажлыг Хан-Уул дүүрэгт хийхээр төлөвлөгдсөн.	70
		Сувагчлалын байгууламжийн урт	Км	1,090	1,102	Улаанбаатар хотод мэдээлэл холбооны ЭАТС, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, сүлжээ зохион байгуулалтыг сайжруулах ажлын зураг төсөл боловсруулагдсан. Моносын уулзвараас хуучин 22-ын товчоо хүртэл, Баянхшуу дэд төвөөс МҮОНРТ-ийн эцсийн буудал хүртэл барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөгдсөн.	70
<b>Стратегийн зорилго 5. “Цахим засаглал” бодлогын зорилтыг дэвшүүлж байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.</b>							
58	5.1. Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах “Чанарын удирдлагын тогтолцоо”-ны баримт бичиг боловсруулж хэрэгжүүлнэ.	Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001: 2016 стандарт нэвтрүүлнэ	Хувь	-	100	Олон Улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд: - “Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт”, нэвтрүүлэх дэд ажлын хэсгийг Газрын даргын 2023 оны A/01 дүгээр тушаалаар байгуулсан. - “Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх хамрах хүрээ, ажлын төлөвлөгөөг Газрын даргын 2023 оны A/09 дүгээр тушаалаар баталсан.	90

1	2	3	4	5	6	7	8
						<ul style="list-style-type: none"> <li>- 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Хотын стандарт, хяналтын газраас зөвлөн туслах чиг үүргийн хүрээнд Хотын стандартын хөгжлийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэнтэй уулзалт зохион байгуулж мэдээлэл авав.</li> <li>- Ажлын хэсгийн гишүүдийн дижитал мэдээлэл солилцох Google drive (share) дэд ажлын хэсгийн гишүүдийн мэдээлэл оруулсан.</li> <li>- 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын А/54 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажил хариуцсан мэргэжилтэн нар ажлын явцтай танилцаж, чиглэл өгөв.</li> <li>- Стандарт нэвтрүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу байгууллагын зөрүүгийн шинжилгээ, орчны шинжилгээ, сонирхогч талыг тодорхойлох, үйл явцыг тодорхойлох шинжилгээ хийх зэрэг 13 удаагийн сургалт, практик ажиллагаанд хуваарийн дагуу нийт албан хаагчид болон ажлын хэсгийн гишүүд хамрагдсан.</li> <li>- Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлын зөвлөх үйлчилгээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээний дагуу “Монголын менежментийн зөвлөхүүдийн холбоо” ТББ-аас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэн, 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл авсан.</li> <li>- Байгууллагын төлөв байдал, хамрах хүрээ, бодлого, зорилтыг тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны процесс зураглалуудыг тодорхойлж гаргасан. Газрын чанарын менежментийн гарын</li> </ul>	

1	2	3	4	5	6	7	8
						авлагыг хүлээн авсан. Сүүлийн хяналтын шатны ажил хийгдэж байна. - Байгууллагын зүгээс зөвлөх үйлчилгээний ажлыг дүгнүүлэх хүсэлтийг 2023 оны 01/01/3364 дугаартай албан бичгээр хуруулсэн.	
59		eBarilga нийслэлийн хот байгуулалтын цахим систем, гар утасны апликешиング хэрэглээнд нэвтрүүлнэ	Хувь	-	100	Байгууллагын үйл ажиллагаагаа бүрэн цахимжуулж, хот төлөвлөлт, барилга байгууламжийн зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй, шуурхай хүргэх зорилгоор "ebarilga" нийслэлийн Хот байгуулалтын цахим системийг ашиглалтад оруулан тус системээр 8 бүлгийн 36 үйлчилгээг узүүлэн ажиллаж байна.	100
60	5.2. Байгууллагын үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэнэ.	eBarilga нийслэлийн хот байгуулалтын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийнэ	Хувь	-	-	- Нэмэлт санхүүжилтийн төсөв батлагдаагүй. - Дэлхийн банк группийн гишүүн Олон Улсын санхүүгийн корпораци, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээний дагуу eBarilga нийслэлийн Хот байгуулалтын цахим системд зайн хэмжих, талбай бодох модулийг нэмж оруулсан. Иргэн, хуулийн этгээд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр /ХҮР, ДАН/ нэвтрэн орж, орон зайн мэдээллийг ашиглан өөрийн эзэмшил газарт барилгажих талбайг мэргэжилтний оролцоогүйгээр урьдчилсан тооцоолол хийх боломжийг бүрдүүлсэн. Мөн орон зайн өгөгдөл түшиглэсэн төслийн концепц боловсруулах уралдаан зарласантай холбогдуулан Хот байгуулалтын мэдээллийн сангаас 10 төрлийн өгөгдөл мэдээллийг геопортал дээр байршуулж хамтран ажилласан.	30
<b>Стратегийн зорилго 6. Хүний хөгжил, байгууллагын хүний нөөцийн бодлогыг сайжруулж ажлын бүтээмжийг дээшлүүлнэ.</b>							
61	6.1. Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн богино, дунд хугацааны сургалтад	Улсын төсвийн санхүүжилтээр Удирдлагын Академид гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын	Toо	6	3	Удирдлагын академийн Богино хугацааны зорилтот сургалтад 4 албан хаагч хамрагдсан. - Төрийн захиргааны Ахлах түшмэлийн багц сургалтад 1 албан хаагч суралцаж байгаа,	100

1	2	3	4	5	6	7	8
	хамруулах, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлнэ.	төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах мэргэшүүлэх багц сургалт				- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагч суралцаж байгаа, - "Чадамжид сууринсан хүний нөөцийн удирдлага" сургалтад 1 албан хаагч хамрагдаж гэрчилгээ, - "Баг, хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтад ажиллах сургач багш бэлтгэх сургалт"-д 1 албан хаагч хамрагдаж сургач багшийн гэрчилгээг гардаж авсан.	
62		Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв болон бусад мэргэжлийн байгууллага, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулагдах төлөвлөгөөт болон цагийн чанартай сургалт	Хувь	100	100	Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан 108 удаагийн сургалтад (цахимаар 38, танхимын 70) давхардан тоогоор 910 албан хаагч (100 хувь) хамрагдav.	100
63		Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Хувь	80	80	Албан хаагчдын ажиллах нөхцөл, ажлын байрны орчны талаар сэтгэл ханамжийн судалгааг цаасаар болон googleform ашиглан явуулсан цахим судалгаанд 68 албан хаагч хамрагдav.	100
64	6.2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлнэ.	Албан хаагчдыг орчин үеийн шаардлага, ажлын байрны онцлогт нийцсэн, ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн цахим мэдээллийн систем, техник хэрэгслээр үе шаттайгаар хангаж, ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх	Хувь	70	70	Байгууллагын сервер, сүлжээний тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, программ хангамж, техник хангамж, эд анги, дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангаж ажилласан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эрх шилжин ирсэн "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд сууринсан газар олгох, барилга барих ўйл	100

1	2	3	4	5	6	7	8
						ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгох" төсөл арга хэмжээний хүрээнд 2 компьютер, сервер, дэлгэц зэрэг тоног төхөөрөмжийг актаар хүлээлцэж албан хэрэгцээнд ашиглаж байна. Газраас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний бүрдүүлэх бичиг баримтыг цахим хэлбэрт хөрвүүлж, цахим сан үүсгэн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор баримт бичгийг цахимд хувиргах Canon сканнер 2-ыг шинээр худалдан авч техник ажиллагааг хялбаршуулан, баримт бичгийн цахим архив үүсгэн ажиллаж байна.	
65	Албан хаагчдыг хөдөлгөөний хомсдол, халдварын бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрөөх боломжийг бүрдүүлж, хэрэгжүүлэх	Too	-	2		Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 онд баталсан "Ажлын байрны дасгал"-ыг egr.ulaganbaatar.mn дотоод удирдлагын нэгдсэн системээр ажлын өдрүүдийн 11:00, 15:00 цагуудад гарах үеэр нийт албан хаагчид хийж хэвшсэн.	100
66	Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан зардлыг нь хариуцах, бие бялдраа чийрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нөхөх төлбөр олгох	Too	-	98		Газрын даргын 2023 оны Б/139 дүгээр тушаалаар газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд 76 албан хаагчийг хамруулж, Сөүл эмнэлэгтэй гэрээ байгуулав. Нэг хүний 96,000 төгрөг, нийт 7,300,000 төгрөгийг шийдвэрлүүлэв. Эмнэлгийн үзлэг шинжилгээнд 60 албан хаагч хамрагдav. Улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгооны үйл ажиллагааны хэрэгжилт 2022 оны 05 дугаар сараас 2023 оны 05 дугаар сарыг хүrtэл хамрагдалт 34%, байгууллагын албан хаагчдын эрт илрүүлэгд хамрагдсан 15 албан хаагч буюу 20%. Улсын хэмжээнд эрт илрүүлэг, үзлэг шинжилгээг 2024 оны 05 дугаар сар хүrtэл	90

1	2	3	4	5	6	7	8
						дахин 1 жилээр сунгасан тул дээрх үзлэг шинжилгээнд хамрагдаагүй 61 албан хаагчид цалинтай чөлөө олгож, эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 54 албан хаагч хамрагдсан байна. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд мөнгөн урамшуулал (5 удаа, давхардсан тоогоор 220 албан хаагч), нэмэгдэл хөлс (9 удаа, давхардсан тоогоор 321 албан хаагч), шагнал (37 албан хаагч), тэтгэмж (19 албан хаагч), захиргааны чөлөө (19 албан хаагч), эмнэлгийн үзлэг шинжилгээнд (76 албан хаагч), хүүхдийн баяр, шинэ жилийн баярыг тохиолдуулан (147 албан хаагч) бэлэг олгож тус тус нийгмийн баталгааг хангаж ажилласан байна.	
67	Эрүүл мэндийн шалтгаанаар гадаад, дотоодод эмчлүүлэх болон бусад төрлийн дэмжлэг туслалцааг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу үзүүлэх	Too	5	5		Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 28 албан хаагчид 5,400,000 төгрөгийн тэтгэмж, цалинтай чөлөөг 14 албан хаагчид (104 ажлын хоног), цалингүй чөлөөг 5 албан хаагчид (43 ажлын хоног) тус тус Газрын даргын тушаалаар (5-аас дээш хоногийн захиргааны чөлөө) олгов. Тэтгэмж олгосон байдал: - Шинэ хүүхэдтэй болсон 8 албан хаагч 1,200,000 төгрөг, - Сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан 4 албан хаагч 2,000,000 төгрөг, - Ажил явдал гарсан 6 албан хаагч 1,200,000 төгрөг, - Яаралтай хагалгаанд орсон 1 албан хаагч 1,000,000 төгрөг. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 59 албан хаагчийн 16 хүртэлх насны 112 хүүхдэд баяр хүргэж, (1 хүүхэд 40,000 төгрөг) 4,480,000 төгрөгийн хөрөнгийг Газрын даргын 2023 оны Б/72	100

1	2	3	4	5	6	7	8
						дугаар тушаалаар, шинэ жилийн баярыг тохиолдуулан 88 албан хаагчийн гэр бүлд бэлэг олгох (1 гэр бүлд 70,000 төгрөг) 6,930,000 төгрөгийн хөрөнгийг Газрын даргын 2023 оны Б/162 дугаар тушаалаар тус тус шийдвэрлэв.	
68		Хамт олны идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, ажил мэргэжлийн туршлага солилцох арга хэмжээг 1-ээс доошгүй удаа зохион байгуулах	Тоо	1	1	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цасны баяр, өвлүүн биеийн тамир, спортын арга хэмжээний хүрээнд "НИЙСЛЭЛ ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ-2023" сэдэвт цасан хотхон байгуулан оролцох арга хэмжээнд амжилттай оролцон "СЭЛБЭ" төслөөр мөсөн хотхон байгуулан I байр, цасан дээрх бүжиг тэмцээнээр II байр, багийн нийлбэр дүнгээр II байранд шалгаран цом, мөнгөн шагналаар шагнагдас.</li> <li>- Нийт албан хаагчдыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд уриалах, хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж бие бялдраа чийрэгжүүлэх, эрүүл зөв амьдралын дадал хэвшил суулгах зорилгоор "Спорт-Эв нэгдэл-Эрч хүч-Нэхөрлөл" урианы дор 2023 оны 04 дүгээр сарын 05-аас 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд байгууллагын нийт албан хаагчид 7 хоногт нэг удаа спорт зааланд тоглохоор зохион байгуулсан.</li> <li>- "Улаанбаатар Марафонд нэгдэцгээ" аянд нэгдэн нийт 3 албан хаагч амжилттай оролцсон.</li> <li>- Албан хаагчдын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа чийрэгжүүлэх зорилгоор спортын 6 төрөлт тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулсан.</li> </ul>	100

1	2	3	4	5	6	7	8
69	6.3. Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлнэ.	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгоно	Хувь	100	100	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг нэгж, албан хаагчдад танилцуулан, 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 01/01/379 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн A/511 дүгээр захирамжаар 24 албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн тогтоосон байна. (18 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, шинээр 6 албан хаагчид)	100
70		Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж, ур чадварын болон төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг олгоно	Тоо	10	10	Төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 74 албан хаагчид журмын дагуу тогтоож, 49 албан хаагчийн зэрэг дэвийн, 7 албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, холбогдох журмын дагуу тус тус нэмэгдүүлэв.	100
70		Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, өдрийн хоолны мөнгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, илүү цагийн нэмэгдэл хөлсийг ажлын зайлшгүй шаардлагаар ажилласан албан хаагчдад холбогдох журмын дагуу олгох	Хувь	100	100	Илүү цагийг 9 удаа давхардсан тоогоор 321 албан хаагчид 110,930,248 төгрөгийн нэмэгдэл хөлс олгов. Нийслэлээс баталсан төсвийн хүрээнд нэг албан хаагчид өдрийн хоолны мөнгө 9000 төгрөг, унааны зардал 1000 төгрөгийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн олгож байна.	100
72		Хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын үр дүнтэй уялдуулан олгож, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах	Тоо	161	98	2023 оны эхний хагас жилээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан журмын дагуу 71 албан хаагч ажлаа тайлагнасан. Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулалт олгох журам"-ын дагуу 2023 оны эхний хагас ажлын үр дүнгээр	100

1	2	3	4	5	6	7	8
						"Маш сайн", "Сайн" үнэлэгдсэн 69 албан хаагчид Газрын даргын 2023 оны Б/109 дүгээр тушаалаар үр дүнгийн 52,304,118 төгрөгийн урамшуулал олгов. - Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 2023 жилийн эцсийн ажлын үр дүнгээр "Маш сайн", "Хэвийн" үнэлэгдсэн 73 албан хаагчид Газрын даргын 2023 оны Б/164 дүгээр тушаалаар үр дүнгийн 82,573,016 төгрөгийн урамшуулал олгов. (4 албан хаагч 1 бүтэн улирал ажиллагаагүй тул журмын дагуу дараагийн үнэлгээнд тооцохоор шийдвэрлэсэн).	
73		Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, эерэг харилцаа хандлага, мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагааны шалгуурыг харгалзан Тэргүүний албан хаагчдыг төрийн дээд цол, одон, медалиар шагнуулахаар тодорхойлох, холбогдох журмын дагуу мөнгөн шагнал олгох	Тоо	59	30	Ардын хувьсгалын 102 жилийн ой, Улсын их баяр наадам, Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 97 жилийг ой, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтололын баярын өдрийг тохиолдуулан хамт олноо манлайлан амжилт гарган ажилласан 54 албан хаагчийг нэр дэвшүүлж тодорхойлолт хүргүүлснээс 37 албан хаагч шагнагдав.	100
74	6.4. Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд Газрын хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	Хөдөлмөрийн дотоод журамд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын зохицуулалтын хүрээнд тэтгэмж, тусlamж олгохтой холбоотой харилцааг шинэчлэн тусгаж, шаардлагатай бусад журамд хамт олны саналыг тусган тухай бүр нэмэлт,	Хувь	100	100	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засгийн газрын 2022 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоо тухай" 488 дугаар тогтоол, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" батлах тухай 491 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны "Төрийн албан хаагчийн хувийн	100

1	2	3	4	5	6	7	8
		өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж, мөрдөх				хэрэг хөтлөх журам" батлах тухай 600 дугаар тогтоол, 2023 оны "Төрийн албаны шалгалт өгөх болзول болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам" батлах тухай 25 дугаар тогтоол зэргийг тус тус үндэслэн газрын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулан Газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлав. Журмын төслийг нийт албан хаагчаар хэлэлцүүлж, гарсан саналыг тусган 100 хувийн саналаар батлав.	

Нийт 6 зорилго, 25 зорилт, 74 арга хэмжээний хэрэгжилт 73,6 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" үзүүлэлттэй байна. Үүнээс:

100%-ийн хэрэгжилттэй 32 арга хэмжээ,  
90%-ийн хэрэгжилттэй 9 арга хэмжээ,  
70%-ийн хэрэгжилттэй 15 арга хэмжээ,  
30%-ийн хэрэгжилттэй 13 арга хэмжээ,  
0%-ийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ байна.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН: ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч.БАДАМХАНД

Л.АДЬЯСҮРЭН